



X/2021


Тархаасан: 11 дүгээр сарын 15



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.5 хувиар өслөө

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс болон өмнөх оны эцсээс тус тус 9.7 хувь, өмнөх сараас 0.5 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 18.2 хувь (мах, махан бүтээгдэхүүн 23.7 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 10.0 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 7.0 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 16.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард өмнөх оны эцсээс 9.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 14.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.1 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 16.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.5 хувиар өсөхөд орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.5 хувиар буурсан хэдий ч, хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2021 оны 10 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	<u>2021 X</u> 2020 X	<u>2021 X</u> 2020 XII	<u>2021 X</u> 2021 IX
Ерөнхий индекс	100.0	109.7	109.7	100.5
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	118.2	114.7	102.2
Согтууруулах ундаа, тамхи	4.4	104.6	104.4	100.8
Хувцас, бөс бараа, гутал	16.6	104.1	103.6	101.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	101.0	111.7	94.5
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	107.1	106.6	100.7
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	107.0	106.1	100.8
Тээвэр	14.4	116.6	116.7	100.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	101.6	101.5	100.3
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	102.9	102.8	100.1
Боловсролын үйлчилгээ	4.8	103.6	103.6	100.6
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	112.4	112.4	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.4	106.6	106.1	100.4

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 10 дугаар сард сард 6.3 хувь, 2019 оны 10 дугаар сард 7.6 хувь, 2020 оны 10 дугаар сард 2.4 хувь гарч байсан бол 2021 оны 10 дугаар сард 9.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 7.3 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 2. ИНФЛЯЦАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгжээр, жил бүрийн 10 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2018 X	2019 X	2020 X	2021 X
Ерөнхий индекс	6.3	7.6	2.4	9.7
Хүнсний бараа, ундаа, ус	1.3	3.5	1.0	4.8
Согтууруулах ундаа, тамхи	0.3	0.1	0.2	0.2
Хувцас, бөс бараа, гутал	0.6	1.3	0.8	0.7
Орон сууц, ус, цахилгаан, түлш	1.1	0.9	0.3	0.1
Гэр ахуйн тавилга, бараа	0.3	0.2	0.2	0.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.5	0.2	0.1	0.3
Тээвэр	1.2	-0.1	-0.6	2.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.0	0.0	0.0	0.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.3	0.3	0.0	0.1
Боловсролын үйлчилгээ	0.3	0.5	0.0	0.2
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.1	0.3	0.2	0.4
Бусад бараа, үйлчилгээ	0.3	0.3	0.3	0.4

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард улсын хэмжээнд 9.7 хувь гарсны 4.8 нэгж хувь буюу 49.5 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.


ХҮСНЭГТ 3. ИНФЛЯЦАД ИМПОРТЫН БАРААНЫ ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгж хувиар, жил бүрийн 10 дугаар сард

Үзүүлэлт	2019 X		2020 X		2021 X	
	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь
Ерөнхий индекс	7.6	100.0	2.4	100.0	9.7	100.0
Импортын барааны нөлөө	2.3	30.3	1.0	41.7	4.6	47.4

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлж байна.

Инфляц 2021 оны 10 дугаар сард 9.7 хувь гарсны 47.4 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 5.7 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ЗУРАГ 2. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар




Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2020 оны 10 дугаар сард 3.8 хувиар, 2021 оны 10 дугаар сард 16.3 хувиар өсөж, өсөлтийн хурдац 12.5 нэгж хувиар, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 10 дугаар сард 1.8 хувиар, 2021 оны 10 дугаар сард 6.7 хувиар өсөж, өсөлтийн хурдац 4.9 нэгж хувиар тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 4. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 10 дугаар сард

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	Ерөнхий индекс	102.4	102.6	102.6	101.8	102.5	102.4
2020 X	Хүнс	103.8	103.3	106.6	104.6	104.5	102.0
	Хүнсний бус	101.8	102.2	101.2	100.8	101.7	102.5
	Ерөнхий индекс	109.7	109.3	110.6	109.4	110.8	109.5
2021 X	Хүнс	116.3	116.3	115.4	116.9	116.3	116.9
	Хүнсний бус	106.7	105.8	108.8	106.5	108.5	106.5

Зүүн болон Хангайн бүсэд 2021 оны 10 дугаар сард хүнсний бүлгийн үнэ 16.9 хувиар, Баруун бүсэд хүнсний бус бүлгийн үнэ 8.8 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 3. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар




Барааны бүлгийн үнэ 2020 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар, 2021 оны 10 дугаар сард 11.1 хувиар өсөж, өсөлтийн хурдац 8.5 нэгж хувиар нэмэгдэж, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 10 дугаар сард 1.9 хувиар, 2021 оны 10 дугаар сард 5.1 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.2 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 5. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, бүсээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 10 дугаар сард

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	Ерөнхий индекс	102.4	102.6	102.6	101.8	102.5	102.4
2020 X	Бараа	102.6	102.6	103.3	102.2	102.9	102.4
	Үйлчилгээ	101.9	102.5	100.5	100.5	101.1	102.4
	Ерөнхий индекс	109.7	109.3	110.6	109.4	110.8	109.5
2021 X	Бараа	111.1	110.6	112.4	110.9	112.5	111.0
	Үйлчилгээ	105.1	105.8	104.5	103.8	103.5	103.5

Төвийн бүсэд 2021 оны 10 дугаар сард барааны бүлгийн үнэ 12.5 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ Улаанбаатар хотод 5.8 хувиар өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 4. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, сараар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2021 оны 10 дугаар сард өмнөх оны эцсээс 22.4 хувиар өсөж, харин өмнөх сараас 0.4 хувиар буурахад үхрийн махны үнэ 0.7 хувь, ямааны махны үнэ 1.4 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Мөн өмнөх оны мөн үеэс 23.7 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 23.6 хувь, хонины ястай махны үнэ 27.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хот:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2021 оны 10 дугаар сард өмнөх сараас өөрчлөлтгүй, өмнөх оны эцсээс 10.4 хувь, өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар өсөхөд орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 2.6 хувиар буурсан хэдий ч хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 18.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 5.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 7.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 14.3 хувь, тээврийн бүлгийн үнэ 17.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард өмнөх оны эцсээс 10.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 15.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 6.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 15.0 хувь, тээврийн бүлгийн үнэ 17.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард өмнөх сараас өөрчлөлтгүй гарахад орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 10.1 хувиар буурсан хэдий ч хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод 2021 оны 10 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 35.2 хувь буюу 121 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 2.3 хувь буюу 8 бараа, үйлчилгээний үнэ буурч, 62.5 хувь буюу 215 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байна. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 76 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар




ЗУРАГ 6. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЦУЛ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2021 оны 10 дугаар сард 15089 төгрөг болж, 2018 оны 10 дугаар сараас 61.2 хувь, 2019 оны 10 дугаар сараас 7.5 хувь, 2020 оны 10 дугаар сараас 19.2 хувиар, өмнөх оны эцсээс 20.2 хувь буюу 2538 төгрөгөөр тус тус өсөж, харин өмнөх сараас 5 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 7. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2021 оны 10 дугаар сард 13277 төгрөг болж, 2018 оны 10 дугаар сараас 69.3 хувь, 2019 оны 10 дугаар сараас 21.3 хувь, 2020 оны 10 дугаар сараас 24.3 хувиар, өмнөх оны эцсээс 18.5 хувь буюу 2069 төгрөгөөр тус тус өсөж, харин өмнөх сараас 1.1 хувь буюу 143 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 8. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2021 оны 10 дугаар сард 11006 төгрөг болж, 2018 оны 10 дугаар сараас 71.0 хувь, 2019 оны 10 дугаар сараас 21.2 хувь, 2020 оны 10 дугаар сараас 28.7 хувь, өмнөх оны эцсээс 28.3 хувь буюу 2427 төгрөгөөр, өмнөх сараас 0.3 хувь буюу 32 төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 9. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ НЭГ ЛИТР АИ-92 БЕНЗИНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2021 оны 10 дугаар сард 2048 төгрөг болж, 2018 оны 10 дугаар сараас 7.3 хувь, 2019 оны 10 дугаар сараас 11.7 хувь, 2020 оны 10 дугаар сараас 43.0 хувь, өмнөх оны эцсээс 43.0 хувь буюу 616 төгрөгөөр, өмнөх сараас 1 төгрөгөөр тус тус өссөн байна.

Аймаг:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс бүх аймагт 5.8-14.2 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард Хөвсгөл аймагт 5.8 хувиар өссөн нь хамгийн бага, Баянхонгор аймагт 14.2 хувиар өссөн нь хамгийн өндөр байна.


ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, ХУВЬ, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР, жил бүрийн 10 дугаар сард (өмнөх оны мөн үеэс)



Аймгуудад 2021 оны 10 дугаар сард худалдаалагдаж буй хонины ястай 1кг махны дундаж үнэ нь 9307 төгрөг болж, 2020 оны 10 дугаар сараас дунджаар 1866 төгрөг, 2020 оны 12 дугаар сараас 1782 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хонины ястай 1кг махны дундаж үнэ 2021 оны 10 дугаар сард Говьсүмбэр, Дундговь аймагт 8000 төгрөг байгаа нь хамгийн бага, Ховд аймагт 12000 төгрөг байгаа нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 11. АЙМГУУДАД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 10 дугаар сард, төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс

Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин

Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс

Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

P_t^i - i барааны тайлант үеийн үнэ

P_o^i - i барааны суурь үеийн үнэ

Q_o^i - i барааны суурь үеийн жин

Хэрэглээний үнийн индексийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. Хэрэглээний үнийн индексийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна.

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.

Эх үүсвэр:

ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

Ангилал, код:

ХЗХБҮА

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2021 оны 12 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын Үнийн
статистикийн хэлтсийн статистикч Д.Батсүх,
Т.Жигжидсүрэн
Утас : (976-51)-261559

